



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 0/250

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 77 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,829,664.00 /таван сая найман зуун хорин есөн мянга зургаан зуун жаран дөрвөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн 77 дугаар цэцэрлэг /О.Баянжаргал/-т зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 10 нэр төрлийн 5,829,664.00 /таван сая найман зуун хорин есөн мянга зургаан зуун жаран дөрвөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 77 дугаар цэцэрлэг /О.Баянжаргал/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

~~ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ~~

Ш.ҮНЭНБАТ



115050000623



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын даргын 2020 оны 06-р сарын 08 -ны өдрийн 0/2020-р тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 77 дугаар цэцэрлэг

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	НӨАУГ-ын мэргэжилтний дүгнэлт	ЭБХХК-н шийдвэр
1	Компьютер таб	8	ш	1	368,500.00	368,500.00	368,500.00	-		Актлах	Татах	Татах
2	Эл Си Ди /проектор/	12	ш	1	2,500,000.00	2,500,000.00	2,500,000.00	-		Актлах	Татах	Татах
3	Компьютер	6	ш	1	1,050,000.00	1,050,000.00	1,050,000.00	-		Актлах	Татах	Татах
4	Компьютер	16	ш	1	889,089.00	889,089.00	889,089.00	-		Актлах	Татах	Татах
5	Ус буцалгагч	7	ш	1	84,000.00	84,000.00	84,000.00	-		Актлах	Татах	Татах
6	Ус буцалгагч	5	ш	1	48,000.00	48,000.00	48,000.00	-		Актлах	Татах	Татах
7	Цахилгаан пийшин	41	ш	1	135,675.00	135,675.00	135,675.00	-		Актлах	Татах	Татах
	Тоног төхөөрөмжийн дүн			7		5,075,264.00	5,075,264.00	-				
8	Багш сандал	8	ш	8	54,800.00	438,400.00	438,400.00		Эвдэрсэн,	Актлах	Татах	Татах
9	Сандал	8	ш	5	28,000.00	140,000.00	140,000.00		ашиглах	Актлах	Татах	Татах
10	Багш сандал	4	ш	4	44,000.00	176,000.00	176,000.00		боломжгүй	Актлах	Татах	Татах
	Тавилга, эд хогшлын дүн			17		754,400.00	754,400.00	-				
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			24		5,829,664.00	5,829,664.00	-				
	Үүнээс : Татан төвлөрүүлэх хөрөнгө					5,829,664.00	5,829,664.00	-				
					Актлах хөрөнгө							